



A global leader  
in multidisciplinary  
research on forced  
migration



## Дана + 20 жил буюу Нүүдэлчин ард түмний тунхаг бичиг

### *Нутгийн нүүдэлчин уугуул ард иргэд, Байгаль хамгаалал, Тогтвортой хөгжил ба Уур амьсгалын өөрчлөлт Данагийн тунхаглалаас хойших 20 жил*

Йорданы Хашемын Хаант Улсын Вади Дана - байгалийн нөөц газар, 2022 оны 9-р сарын 10

#### ХУРААНГУЙ

Нутгийн уугуул, уламжлалт, нүүдэлчин, овог аймгийн зохион байгуулалтаар амьдардаг иргэдийг<sup>1</sup> хамруулсан “нүүдэлчин ард иргэд”-ийн төлөөлөл болсон биднээс гадна энэ талаар тусгайлан санаа тавьж ажилладаг судлаач, дадлагажигч нар, Данагийн тунхаглал<sup>2</sup> гарснаас хойш 20 жилийн дараа өнөөгийн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгч, ирээдүйн төлөвлөгөөгөө боловсруулахаар Йорданы Хашемын Хаант Улсын Вади Дана хэмээх байгалийн нөөц газарт хамтдаа хуран цуглаад байна. Бид бол Монгол, Малайз, Энэтхэг, Иран, Йордан, Швед, Нигери, Камерун, Кени, Танзани, Намиби, Перу зэрэг дэлхийн олон улс орны янз бүрийн ард түмний төлөөлөл болж ирсэн юм. Энэхүү уулзалт хурлыг зохион байгуулахад санхүүжилт олгож, ийнхүү эргэцүүлэн хэлэлцэх хүрээнд Йордан улсад бидэнтэй нэгдэж буй НҮБ-ын төрөлжсөн агентлагууд, иргэний нийгмийн байгууллагууд, нутгийн ард иргэдэд түшиглэсэн байгууллагууд, их дээд сургуулиуд, байгаль хамгааллын байгууллагуудад гүн талархал илэрхийлье.

Монгол улсын Засгийн газрын санаачилгаар<sup>3</sup> НҮБ-ын Ерөнхий Ассамблейн түвшинд харилцан зөвшөөрсний дагуу, удахгүй зохион байгуулах гэж буй “Олон улсын бэлчээр ба нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн жил”-ийн хүрээнд нүүдэлчид ба бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчид бид дэлхий даяарх олон зуун сая хүн амаас бүрдэж байдгийн зэрэгцээ амьдарч буй байгаль орчиндоо дасан зохицсон үрт настай амьдралын арга туршлагыг хуримтлуулсан юм гэдгийг онцлон тэмдэглэж байна. Бидний амьдралын хэв маяг маш олон янз бөгөөд хүрээлэн буй байгаль орчин болон амьдарч буй нутаг дэвсгэртэйгээ харьцах харилцаагаа сайжруулахын тулд нүүдлийн шилжилт хөдөлгөөний олон хэлбэрт тулгуурладаг.<sup>4</sup> Бидний төрөлх нутаг алс хойд хязгаараас эхлэн хуурай, хагас хуурай цөлөрхөг нутаг, халуун бүсийн тал нутаг, түүнчлэн тал хээрээс авхуулаад чийглэг халуун орны ой мод хүртэлх өргөн уудам газар нутгийг хамарч байдаг.

Уур амьсгалын өөрчлөлтөөс болж, хүнс тэжээлийн хувьд бидний бие даасан байдал ба хүнсний аюулгүй байдал, өвс тэжээлийн хүрээмжид заналхийлж буй газрын доройтол, их хэмжээний үер, удаан үргэлжлэх ган гачиг, түүнээс улбаалсан цөлжилт үүсэх, мөн ой модыг ихээр огтлох, биологийн төрөл зүйл алдагдах зэрэг урьд өмнө хэзээ ч байгаагүй сорилтуудтай манай ард иргэд тулгарч байна. Эдгээр асуудлууд нь үндсэндээ малтмал түлшний хэрэглээнээс болж ялгарсаар буй нүүрсхүчлийн хийнээс шалтгаалдаг боловч уламжлалт амьдралын хэв маягаа үргэлжлүүлж буй биднийг ихэвчлэн

<sup>1</sup> IFAD 2009. Engagement with Indigenous Peoples Policy, IFAD, Rome.

<sup>2</sup> The Dana Declaration, Dana + 10 and Dana + 20 fully endorse the implementation of the UN Declaration on the Rights of Indigenous Peoples. See the Dana Declaration website: <https://www.danadeclaration.org/>.

<sup>3</sup> <https://iyp.info/>

<sup>4</sup> <https://www.biodiversity-a-z.org/content/indigenous-peoples-and-community-conserved-territories-and-areas-icca>

гол буруутан болгох нь олонтаа. Гэтэл олборлох үйлдвэрлэл явуулдаг компаниудыг ямар ч сорилтгүйгээр үлдээсэн хэвээр байна.

Бид хувьсах чадварт зохицсон манай уламжлалт буюу нүүдлийн зарчимтай газар зохион байгуулалтын стратеги ба мэдлэгт суурилсан, уур амьсгалын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ болон дасан зохицох төлөвлөгөө боловсруулахыг уриалж байна.<sup>5</sup> Энэ нь бид өөрсдийн нутаг дэвсгэртээ аюулгүй аж төрөх эрхтэй байж, ингэснээр шилжилт хөдөлгөөнөөс үүдэлтэй уян хатан тэсвэртэй чанар маань алдагдахгүй байхыг шаардаж байна.

Нийтлэг тогтсон ойлголтоос ялгаатай нь, бидний амьдардаг нутаг дэвсгэр, бэлчээр нь биологийн олон янз байдлын чухал нөөц болохын хувьд экосистемд нэн чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд бидний амьдралын хэв маяг нь эдгээр бүс нутгийг тогтвортой байлгах, удирдан зохицуулахад чухал үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ, үндэсний эдийн засаг, хүнсний аюулгүй байдалд онцгой хувь нэмэр оруулж байдаг билээ. Эдгээр нүүдлийн аж амьдралын хэлбэрүүд нь уян хатан тэсвэртэй чадвар болон хөрс ба усны нөөцийн үр дүнтэй зохицуулалтыг сайжруулах арга хэлбэрүүдийг бий болгодог бөгөөд энэ нь байгаль орчныг хамгаалах ба нөхөн сэргээх үйл ажиллагааны үндэс сүүр нь болох ёстой юм. Эдгээр чухал асуудлыг НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенц зэрэг олон улсын байгууллагууд албан ёсоор хүлээн зөвшөөрч байгаад бид талархаж байна.<sup>6</sup> Ан агнуур, жимс ногоо түүх, ойн уриншийг өнжөөж ээлжлэн бэлдэх, шинэ бэлчээрт малаа оторлуулах, 'нүүдлийн' мал аж ахуй буюу бэлчээрийн газраа харилцан хуваалцаж ашиглах зэргээр байгалийн нөөцийг нүүдэллэн ашиглах нь биологийн төрөл зүйл, экосистемийн уян хатан тэсвэрлэх чанарыг бууруулна гэхээс илүү сайжруулдаг гэж үздэг бидний мэдэгдлийг эрдэм шинжилгээний судалгаа нотолсоор байна. Гэсэн хэдий ч хүн амын өсөлт, газар нутаг болон усны нөөцөө бусдын ашиг сонирхолын гарт алдах, ихэвчлэн тааламжгүй нөхцөлтэй байдаг бэлэн мөнгөний эдийн засгийн харилцаанд хэт оролцох зэргээс болж бидний хүрээлэн буй орчин, амьдралын хэв маяг доройтож байгааг бид харж байна. Бид амьжиргаагаа дэмжиж тогтвортой байлгахын тулд та бүхнийг олон түвшинд бидэнтэй эвсэн ажиллахыг уриалж байна.

Түүхэнд бидний амьдралын хэв маяг, хүний эрхийг олон тохиолдолд үнэ цэнийг нь бууруулж, үгүйсгэдэг байсан. Бидний зарим нь хүчирхийлэлд өртөж, албадан нүүлгэлтэнд өртөж, суурьшмал амьдралд шилжүүлэх үйл явцад өртөж байлаа. Суурин тариаланчдад тохирсон тэр нэгэн адил эрхийг бидэнд олгохгүй байхаар хуулийг хайрцаглан гаргасан байсан. Бидний хувьд газар нутаг дэвсгэртээ эзэн суух, байгалийн нөөц эх үүсвэрээ эзэмших эрх, өөрөө өөрийгөө удирдах ёс болон заншлын хэм хэмжээнд үндэслэсэн хууль журмаа хэрэгжүүлэх эрх хамгаалагдсангүй. Өдгөө манай улс орнуудын хувьд тусгаар тогтнолоо олж, хүний эрхийн олон улсын гэрээ хэлэлцээр, конвенцийг<sup>7</sup> соёрхон баталсан ч, иймэрхүү ялгаварлан гадуурхсан соёлын өрөөсгөл ойлголт, хууль тогтоомж, бодлого тэсвэртэй баримтлагдсан хэвээр байна. Газар нутаг, хүний эрхийг хамгаалагчид манай нийгэм, нутгийн ард иргэдэд чухал үүрэг гүйцэтгэдэг гэдгийг бид хүлээн зөвшөөрдөг. Бид Засгийн газрууд болон олон улсын хамтын нийгэмлэгт нүүдэлчин ард иргэд болон тэднийг хүрээлэн буй орчныг хамгаалах талаар үйл ажиллагаандаа тусган ажиллахыг уриалж байна.<sup>8</sup>

Өдгөө бидний амьдралын хэв маягт, олборлох үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн бизнес, албадан ногдуулсан тусгай хамгаалалттай газар нутаг, спорт агнуур, аялал жуулчлалын баазууд, нүүлгэн

<sup>5</sup> See CELEP video: <https://www.youtube.com/watch?v=DeqITzac9Ac>

<sup>6</sup> See for example: <https://www.unccd.int/news-stories/statements/indigenous-peoples-dialog-climate-change-biodiversity-and-desertification>

<sup>7</sup> And other global instruments that address Indigenous Peoples' collective rights such as UN Declaration on the Rights of Indigenous Peoples, ILO 169, and VGGT.

<sup>8</sup> [UN Declaration on Human Rights Defenders](#),

шилжүүлэлт, суурин иргэншилд шилжүүлэх хөтөлбөрүүд, шударга ёсны хүртээмжгүй байдал, бидний амьдралын хэв маягийн эсрэг нэгэнт газар авсан ялгаварлан гадуурхал, бидний заншлын хэм хэмжээнд үндэслэсэн засаглалын тогтолцоо болон уламжлалт мэдлэгийг үл хүндэтгэх болсон явдал зэрэг нь улам бүр заналхийлсээр байна. Манай нутаг дэвсгэрийг хэсэгчилэн хувааж мөн энэ газар нутаг дээр минь хувьчлан авсан үл хөдлөх эд хөрөнгөө хашаалах мөн үндэсний хэмжээнд шинэ хил хязгаар тогтоож бидний уламжлалт нүүдэллэх замыг хааж, бэлчээр ба ой мод руу нэвтрэх боломжийг алдагдуулж байна. Байгаль хамгаалал, бүтээн байгуулалт нэрийн доор хориглосон нөхцөлүүдээр бидний эрхэд зогсоо зайгүй халдаж байгаа нь бидний өөрсдийн газар, нутаг дэвсгэртээ нэвтрэх эрхийг алдагдуулж, сайн дурын бус үндсэн дээр дахин суурьшиж, ядууралд хүргэж, соёл уламжлалаа алдахад хүргэж байгааг онцолж байна. Салхин болон нарны цахилгаан станц, газрын ховор элементийн олборлолт зэрэг шинэ “Ногоон шилжилтийн” төслүүдийг хүртэл бидний зөвшөөрөлгүйгээр газар нутагт маань тулган барьж байгаа нь тухайн газрыг эзэмших бидний эрх, ашиглах эрх, хэрэгцээг огт бодолцохгүй байгаа хэрэг юм.

Бидэнд тулгарч буй зарим асуудлыг шийдвэрлэх загвар санаачилгууд байдаг болохыг бид хүлээн зөвшөөрч, сайшааж байдаг. Зарим тохиолдолд шүүхийн шийдвэрээр манай ард түмний газар нутгаа эзэмших зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоосон жишээ бий. Мөн зарим үндэсний Засгийн газрууд манай уламжлалт нутаг дэвсгэрээ өмчлөх ба хяналт тавих эрхийг хүлээн зөвшөөрөхөөр тохиролцож мөн бидэнд газар нутгаа өөрөө удирдах эрхийг зөвшөөрсөн тохиолдол бий. Зарим тусгай хамгаалалттай газар нутгийг иргэдийн өмчлөл, хяналт, удирдан зохион байгуулалтанд буцаан олгож, нутгийн уугуул нутаг дэвсгэр, орон нутгийн байгаль хамгааллын газар нутаг гэх мэт байгаль хамгаалахад чиглэсэн бусад үр дүнтэй арга хэмжээг хүлээн зөвшөөрч эхэлж байна. Манай нутгийн ард иргэдтэй хамтран орон нутгийн хувьд нэн чухал ач холбогдолтой амьдрах орчныг нөхөн сэргээх зарим төслүүдийг хэрэгжүүлсэн. Харамсалтай нь, эдгээр байгальд ээлтэй сайн жишгүүд дүрэм журам гэхээсээ илүү харьцангуй онцгой тохиолдлууд байсан юм.

Бидний өмнө тулгараад байгаа сорилтуудыг шийдвэрлэхийн тулд бид Засгийн газруудад хандаж, нутгийн ард иргэдийг юуны түрүүнд нутаг дэвсгэрүүд ба байгалийн баялгаа хамтран ашиглах заншлын хэм хэмжээнд үндэслэсэн эрхийг нь хүлээн зөвшөөрөн албан ёсоор баталгаажуулж, манай уламжлалт эрх мэдэл, заншлын хэм хэмжээнд үндэслэсэн хууль тогтоомжийг нь хүлээн зөвшөөрч, цаашлаад бидний амьдралын хэв маягийг баталгаажуулсан соёлын мэдрэмжтэй боловсролыг дэмжих замаар мөн залуучуудыг уламжлалт мэдлэг, жинхэнэ өвөрмөц байдлаа эрхэмлэн дээдлэхийг нь хөхиүлэн дэмжих замаар, ард иргэд рүүгээ чиглэсэн бодлогоо өөрчлөн шинэчлэхийг уриалж байна. Нүүдэлчин ард иргэд шийдвэр гаргах түвшинд дуу хоолойгоо хүргэж мөн шударгаар төлөөлөл болох ёстой.

Бид байгаль хамгаалагчдыг бид бүгдийн эрх ашгийг хүндэтгэж, уламжлалт мэдлэг ба заншлын хэм хэмжээнд үндэслэсэн удирдан зохицуулах арга барилаа ашиглах замаар, бидний дээдэлж, хадгалж хамгаалж байдаг өвөг дээдсийнхээ нутаг дэвсгэр, био-соёлын олон янз байдал, экосистемийг хамгаалахын тулд, бидэнтэй нягт хамтран ажиллахыг уриалж байна. “Дурбаны зөвшилцөл”<sup>9</sup> ба “Дурбаны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хүрээнд, “Биологийн олон янз байдлын тухай конвенцэд нэгдсэн Талуудын бага хурал”-ын<sup>10</sup> шийдвэр, “Биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээний талаарх Засгийн газрууд хоорондын платформ”<sup>11</sup>-ын (IPBES) холбогдох “Гол санаанууд”-ын дагуу амлалтаа хэрэгжүүлэхийг мөн тэдэнд сануулж байна. Бид тэднийг Вакатане механизмыг (Whakatane Mechanism) бодитой үр дүнд хүргэж, нөөц эх үүсвэрийг дайчлан ажиллахыг уриалж

<sup>9</sup> Endorsement Dana Declaration in 5.2.7 and in the 4<sup>th</sup> World Conservation Congress in Barcelona

<sup>10</sup> CBD COP 7 Decision 28, COP 10 Decision 2, COP 12 Decision 12, COP 14 Decision 8, all with their respective annexes.

<sup>11</sup> IPBES ‘Key messages’ A6, B6 and D5 of Global Assessment.

байна. Ингэснээр бусдын нөлөөлөлд өртсөн ард иргэд хамгаалалттай газар нутгийн талаарх өөрсдийн санаа зовоож буй асуудлаа дэвшүүлж, түүнийгээ шударгаар шийдвэрлүүлэх, зөрчигдсэн эрхээ сэргээлгэж, нөхөн олговор авч, мөн эвлэрүүлэн зуучлуулах үйлчилгээний замаар асуудлаа шударгаар ил тодоор шүүлгүүлэн шийдвэрлүүлэх бололцоо бүрдэх юм.

Бид манай нутгийн ард иргэдийн эрхийг хүндэтгэж, Акве:коны (Akwe: Kon) удирдамжийн<sup>12</sup> дагуу нийгэм, эдийн засаг, соёл, байгаль орчны нөлөөллийн үнэлгээг тэдний бүрэн оролцоотой явуулахыг корпорацуудад уриалж байна. Бид мөн корпорацуудыг журмын дагуу, бидний өөрсдийн сонгосон төлөөллүүдээр дамжуулан, өөрсдийн боловсруулсан саналынхаа талаар бүрэн дүүрэн мэдээллийг хуваалцаж мөн зөвхөн бидний Эрх чөлөөт, урьдчилж мэдээлэл авснаар олгох зөвшөөрөл (FPIC)-ийг авсны үндсэн дээр л, манай заншлын хэм хэмжээнд үндэслэсэн нутаг дэвсгэр дээр тэдгээр төслүүдээ хэрэгжүүлэхийг уриалж байна. Корпорациуд нь учруулсан аливаа алдагдал, хохирлыг шударгаар нөхөн төлж барагдуулах ёстой.

Бидний хүчин чармайлтыг дэмжиж, эв санааны хувьд бидэнтэй нэгдэж, бидний өөрсдийн санаачлагыг дэмжих замаар санхүүжилт олгохыг НҮБ-ын агентлагууд, их дээд сургуулиуд, Иргэний нийгмийн байгууллагууд болон Нутгийн ард иргэдэд түшиглэсэн байгууллагуудад уриалж байна. Ялангуяа, бид НҮБ-ын Уугуул иргэдийн асуудлаарх байнгын форум буюу Уугуул иргэдийн эрхийг хамгаалах шинжээчдийн механизмыг тусгайлсан магадлан шинжилгээ явуулж, Нүүдэлчин уугуул иргэдийн нөхцөл байдлын талаар тайлан нийтэлж, бидний эрхийг хэрхэн хангах талаар тодорхой зөвлөмж гаргахыг уриалж байна.

Мөн бид судлаачдаас Эрх чөлөөт, урьдчилж мэдээлэл авснаар зөвшөөрөл олгох (FPIC) эрхийн дагуу бидэнд нэн тэргүүнд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх чиглэлээр хамтран ажиллах судалгааны санаачилгыг хамтран боловсруулж, орон нутгийн судлаач, залуучуудын чадавхийг нэмэгдүүлэхийг хүсч байна. Ийм судалгаа нь хөгжлийн болон байгаль хамгаалах агентлагуудаас хараат бус байх ёстой бөгөөд нийтэд тараан түгээхээс өмнө манай нутгийн ард иргэдтэй эргээд хуваалцах замаар баталгаажуулах ёстой. Тэдгээр судалгааны үр дүнг мөн олон нийтэд ил тод болгох хэрэгтэй.

Мөн бид эмэгтэйчүүд, залуучуудын үүрэг оролцоог хангаж, өөрсдийн түвшинд идэвхитэй дайчилан ажиллаж, сүлжээгээ бэхжүүлэн, дэлхийн түвшинд өмгөөллийн ажил хийх, хямралын үед бие биенээ дэмжихийн тулд хамтран, эв нэгдэлтэй ажиллаж, өөрсдийн хэрэгцээнд нийцсэн хэвлэл мэдээллийн нийтлэлүүдийг бий болгохыг амлаж байна. Бид одоо байгаа орон нутаг, үндэсний болон бүс нутгийн түвшний холбоо, байгууллага, сүлжээнүүдээ үргэлжлүүлэн бэхжүүлэх болно.

Бид энэхүү тунхаглалыг манай дэлхийн ирээдүйд нүүдэлчин амьдралын хэв маяг ямар чухал байр суурь эзэлдэг талаарх харилцан ойлголцлыг гүнзгийрүүлэх, асуудлыг хөндөж буй холбогдох талуудын хамтын ажиллагааны шинэ гарцуудыг нээж ажиллахад зориулсан нээлттэй урилга хэлбэрээр санал болгож байна.

---

<sup>12</sup> <https://www.cbd.int/doc/publications/akwe-brochure-en.pdf>

### Тунхаг бичигт гарын үсэг зурсан хүмүүс:

Ariell Ahearn, Departmental Lecturer, University of Oxford, UK.  
 Abd Alrazzaq Al-Khawaldeh, Duty Manager of the Dana Guesthouse, Jordan.  
 Ahmed Al-Khawaldeh, Dana Terraced Gardens Cooperative, Jordan  
 Alejandro Argumedo, International Network of Mountain Indigenous Peoples (INMIP), Peru  
 Raed Hasan Al-Khawaldeh, Tourism Manager of Dana Reserve, Jordan.  
 Mohammad Alnaanah, Dana Livestock Breeders Cooperative, Jordan  
 Salem Mutlak Alzalabih, Wadi Rum, Jordan.  
 Alhassan Jaoji Attahiru, Confederation of Traditional Stockbreeders Organisations (CORET), Nigeria.  
 Mahmoud Abdullah Mohmmed Bdoul, Bdoul tribe, Petra, Jordan.  
 Amer Shehdeh Khawaldeh, President, Dana & Qadisiyah Local Community Cooperative, Jordan.  
 Eng Basem Eid Khawaldeh, Alnawatif Cooperative, Jordan.  
 Khalid Khawaldeh, Global coordinator, World Alliance of Mobile Indigenous People (WAMIP).  
 Sara-Elvira Kuhmunen, President of the Sámi Youth Association, Sweden.  
 Dawn Chatty, Emeritus Professor, University of Oxford, UK.  
 Marcus Colchester, Senior Policy Advisor, Forest Peoples Programme, UK.  
 Alain Frechette, Rights and Resources Initiative, Canada.  
 Jérémie Gilbert, Professor of Human Rights, University of Roehampton, UK.  
 Elizabeth Hempstead, Research Assistant, University of Oxford, UK.  
 Saverio Krätli, Independent Researcher and Editor, *Journal of Nomadic Peoples*, UK.  
 Mohammad bin Pokok, Headman of Kuala Koh Village, Malaysia.  
 Janali Qasemi, Member of the Board, UNINOMAD, Iran.  
 J. Terrance McCabe, University of Colorado, USA.  
 Olivia Mason, Research Associate in Geography, Newcastle University, UK.  
 Simon Maison Tong'oyo, Research and Field Coordinator of ILEPA, founder and director of Nchaischi  
 Vision School, and Majimoto Group Ranch Secretary, Kenya.  
 Nahid Naghizadeh, Chair of the Board, CENESTA, Iran.  
 Bayarsaikhan Namsrai, Steps without Borders NGO, Mongolia.  
 Musa Usman Ndamba, 1st Vice National President MBOSCUDA, Cameroon.  
 Helen Newing, Forest Peoples Programme, UK.  
 Sina Maghami Nick, DPhil student, School of Geography and the Environment, Oxford.  
 Yannick NDOINYO, Executive Director - Traditional Ecosystems Survival Tanzania (TEST), Tanzania.  
 Tumul Orto Galdibe, HSC, Toricha Livestock Breeds Farmer - Private Practice, Kenya.  
 Dayali Devi Raika, Lokhit Pashu Palak Sansthan Sadri, Rajasthan India.  
 Kimaren ole Riamit, Founder-Director of the Indigenous Livelihoods Enhancement Partnership, Kenya.  
 Cory Rodgers, Senior Researcher, University of Oxford.  
 Greta Semplici, PASTRES postdoctoral fellow, European University Institute, Italy.  
 Usiel Seuakouje Kandjii: o'Seu Oningandu – Namibia.  
 Indrani Sigamany, Research Consultant and Capacity Building Specialist, UK.  
 Hanwant Singh, Lokhit Pashu Palak Sansthan Sadri, Rajasthan India.  
 Munkhnasan Tsevegmed, Country Coordinator, International Year of Rangelands and Pastoralists,  
 Mongolia.  
 Cecilia Turin, Andean Pastoralism Researcher, Peru. Member of PASTOAMERICAS.  
 WONG Pui May, conservation practitioner, Malaysia.  
 Mohammad Zayadeen, Azazmih Tribe, Wadi Hidan, Jordan.



“Dana + 20”-ийн спонсоруудад талархал илэрхийлье:

Council for British Research in the Levant (CBRL); Misereor [IYRP]; Oxford University’s Refugee Studies Centre and School of Geography and the Environment; Rights and Resources Initiative; PASTRES; University of Nevada; Wenner Gren Foundation; BMUV; GEF; SGP and UNDP; WAMIP.